



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар *MCS*

Мандалговь

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 31 дүгээр зүйлийн 31.1.2. дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Иргэн Санчир овогтой Батбагана /ЗК77031514/ нь өөрийн хүсэлтээр Сайнцагаан сумын 5-р баг Шандын 4-9 тоотод байршилтай 665м² өмчлөлийн газрынхаа 559м² газрыг өмчлөх эрхээсээ татгалзаж байгаа тул иргэн С.Батбаганы 106м² газрыг өөрийнх нь өмчлөлд хэвээр үлдээж 559м² газрын өмчлөх эрхийг дуусгавар болгосугай.

Хоёр. Газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч /Р.Мөнхтогтох/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 11 дүгээр захирамжийн хавсралтын 10 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

020000057